



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар A/132

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн эрх олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/80 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/, Хяналт шалгалтын газар /Н.Баянмөнх/-т үүрэг болгосугай.



000000739

Гадаадын иргэн, харьяатын газрын
даргын 2020 оны 06 сарын 12-ны
өдрийн А/132 дугаар тушаалын хавсралт

ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧИЙН ЭРХ ОЛГОХ ЖУРАМ

16126983 2712253

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч /цаашид "байцаагч" гэх/-ийн эрх олгох, уг эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Байцаагчийн эрх олгох ажиллагааг зохион байгуулахад ил тод, нээлттэй, шударга ёсны зарчмыг баримтална.

1.3. Байцаагчийн эрх олгох сургалтад хамрагдаж, байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн албан хаагчид байцаагчийн эрх олгоно.

Хоёр. Байцаагчийн эрх олгоход тавигдах шаардлага

2.1. Дараахь шаардлагыг хангасан албан хаагчид байцаагчийн эрх олгоно:

2.1.1. эрх зүйн дээд боловсролтой;

2.1.2. Гадаадын иргэн, харьяатын газар /цаашид "байгууллага" гэх/-т 2-оос доошгүй жил ажилласан, түүнээс 1-ээс доошгүй жил виз, бүртгэлийн чиглэлээр ажилласан туршлагатай;

2.1.3. жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг "хангалттай" болон түүнээс дээш үнэлүүлсэн;

2.1.4. сахилгын шийтгэлгүй;

2.1.5. байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн.

Гурav. Байцаагчийн эрх олгох

3.1. Энэ журмын 2.1.1-2.1.4-т заасан шаардлага хангасан албан хаагч байцаагчийн эрх олгох сургалтад хамрагдах хүсэлтээ сургалтын асуудал хариуцсан нэгжид гаргана.

3.2. Албан хаагчийг байцаагчийн эрх олгох сургалтад хамруулах эсэхийг хариуцсан нэгжийн даргын саналыг харгалзан Байгууллагын дарга шийдвэрлэнэ.

3.3. Байцаагчийн эрх олгох сургалтыг сургалтын болон хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж хамтран зохион байгуулна.

3.4. Байгууллагын дарга байцаагчийн эрх олгох шалгалт авах багийг 3-аас доошгүй гишүүнтэйгээр бүрдүүлнэ.

3.5. Байгууллагын дарга байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн албан хаагчид байцаагчийн эрх олгож, байцаагчийн тангараг өргүүлнэ. Тангараг өргөх ажиллагааг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР
ЭХ ХУВЬ 2020 оны 1/182 дугаар
ТУШААЛ

3.6. Байцаагчийн эрх тухайн албан тушаал хших хугацаанд хадгалагдана.

Дөрөв. Байцаагчийн эрхийг түдгэлзүүлэх

4.1. Байцаагчийн эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

4.1.1. гэмт хэрэгт шалгагдаж байгаатай нь холбогдуулан түдгэлзүүлэх хүсэлт ирүүлсэн;

4.1.2. ёөр албан тушаалд томилогдсон;

4.1.3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн;

4.1.4. тухайн жилд 3 буюу түүнээс дээш удаа ажлын хариуцлага алдаж зөрчлийн хэрэг бүртгэлтийг алдаатай гүйцэтгэсэн бол;

4.1.5. энэ журмын 7.1-д заасан байцаагчийн мэргэшлийн түвшин тогтоо шалгалтад тэнцээгүй;

4.1.6. төрийн албанаас түр чөлөөлөгдсөн.

Тав. Байцаагчийн эрхийг хүчингүй болгох

5.1. Байцаагчийн эрхийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

5.1.1. төрийн албанаас халагдсан, эсхүл чөлөөлөгдсөн;

5.1.2. хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн;

5.1.3. энэ журмыг зөрчиж байцаагчийн эрх олгосон;

5.1.4. төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа болон гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагаанд хориглосон үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон;

Зургаа. Байцаагчийн эрхийг сэргээх

6.1. Энэ журмын 4.1.1-д заасан хүсэлт ирүүлсэн байгууллага үндэслэл арилсан талаар мэдэгдсэн бол түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгож байцаагчийн эрхийг сэргээнэ.


6.2. Энэ журмын 4.1.2-т заасан албан хаагчийг эгүүлэн байцаагчаар томилсоноор байцаагчийн эрх сэргэнэ.

6.3. Энэ журмын 4.1.3-4.1.5-д заасан үндэслэлээр байцаагчийн эрх нь түдгэлзсэн албан хаагч 6 сарын дараа байцаагчийн эрх олгох сургалтад хамрагдан, шалгалт өгч тэнцсэн нөхцөлд байцаагчийн эрхийг сэргээнэ.

6.4. Энэ журмын 5.1.2-5.1.4-т заасан үндэслэлээр байцаагчийн эрх нь хүчингүй болсон албан хаагч 2 жилийн хугацаанд байцаагчийн эрх олгох сургалтад хамрагдах эрхгүй.

Долоо. Бусад

7.1. Байгууллагын сургалтын модулийн дагуу 2 жил тутам байцаагчаас мэргэшлийн түвшин тогтоо шалгалт авна.



7.2. Байцаагчийн эрхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдолд Байгууллагын дарга тушаал гаргах бөгөөд байцаагчийн үнэмлэх, тэмдгийг Байгууллагын төвд захиргааны асуудал хариуцсан нэгж, орон нутагт тухайн харьяалах нэгжийн дарга хүлээн авч, хадгална.

7.3. Албан тушаалтан энэ журмыг зөрчсөн нь түүнд Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

.....ооо.....

